

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: **ӨМА-2025/009/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn Өмнөговь аймаг 2025 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Алтанцэцэг Утас: 8000-7121 Цахим хаяг: tolinetugen@gmail.com Толин этүгэн аудит ХХК-ийн гүйцэтгэх захирал: Б.Отгон-Өлзий Утас: 99844655 Цахим хаяг: otgon1118@yahoo.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2025.02.24 № 39
танай -ны № -т

СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА
Э.АРИУНТУЛГА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сум дундын ойн анги нь ойн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, байгалийн болон таримал ойн сангийн талбайг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх нэгдсэн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 312,894.7 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдээс хандив, тусламжаар 23,500.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан байна.

Бусад асуудлын хэсэг

4625020137

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан хөтөлбөр арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 90.0% хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБӨУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд**

		/мянган төгрөгөөр/	
Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31	
Санхүүгийн байдлын тайлан			
Эргэлтийн хөрөнгийн дүн	381,383.4	1,108,631.1	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,220,272.9	10,091,614.3	
Нийт хөрөнгийн дүн	10,601,656.3	11,200,245.4	
Нийт өр төлбөрийн дүн	-	-	
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,601,656.3	11,200,245.4	
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	10,601,656.3	11,200,245.4	
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
Үйл ажиллагааны орлогын дүн	2,099,704.6	3,159,295.0	
Үйл ажиллагааны зардлын дүн	2,093,964.5	2,447,985.7	
Үйл ажиллагааны үр дүн	5,740.1	711,309.3	
Үйл ажиллагааны бус үр дүн	-	(112,720.3)	
Үйл ажиллагааны нийт үр дүн	5,740.1	598,589.0	
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,595,916.3	10,601,656.4	
Тайлант оны үр дүн	5,740.1	598,589.0	
Эцсийн үлдэгдэл	10,601,656.4	11,200,245.4	
Мөнгөн гүйлгээний тайлан			
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,547,771.1	2,032,191.8	
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,541,589.1	2,009,752.6	
Үйл ажиллагааны ЦМГ	6,182.0	22,439.2	
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(6,182.0)	(22,439.2)	
Санхүүгийн ажиллагааны ЦМГ			
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,696,356.6	1,534,433.5	
Урсгал зардал	1,696,356.6	1,534,433.5	
Хөрөнгийн зардал			
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,696,356.6	1,534,433.5	
Орон нутгийн төсвөөс	1,644,356.6	1,482,993.0	
Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	52,000.0	51,440.5	

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,653.8 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 2 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

3.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

3.3 ЗөвлөмжИлрүүлэлт 1:

Өмнөговь аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 2024 оны 4-8 дугаар сарын "Нутгийн дэм" хөтөлбөрийн мөнгөн урамшууллыг олгохдоо ажил олгогчоос төлөх НДШ 6,917.8 мянган төгрөгийг байгууллагын батлагдсан төсвөөс төлсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
Илрүүлэлт 2:

Нисэх чиглэлийн ойн зурвасын нөхөн тарилт, усалгаа арчилгааг 10 хоногийн хугацаанд хийлгүүлэхээр Мөнхөд арвижих дэлгэрэх билэг ХХК-тай 9,936.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж 5,736.0 мянган төгрөг шилжүүлэн үр ашиггүй зардал гаргасан байна.

Өгсөн зөвлөмж:

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөговь аймгийн ЗД-ын захирамжийн дагуу 2024.04-2024.08 дугаар сарын Нутгийн дэм хөтөлбөрийн мөнгөн урамшууллыг олгохдоо ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 6,917.8 мянган төгрөгийг байгууллагын батлагдсан төсвөөс гаргаж төлсөн байна.	1	6,917.8					1	6,917.8		
Өмнөговь аймгийн ЗД-ын захирамжаар Нисэх чиглэлийн ойн зурвасын нөхөн тарилт, усалгаа арчилгааг 10 хоногийн хугацаанд хийлгүүлэхээр Мөнхөд арвижих дэлгэрэх билэг ХХК-тай 9,936.0 мянган төгрөгийн гэрээг байгуулж, 5,736.0 мянган төгрөгийн усалгааны ажлыг өөрийн ажилчдаар хийлгээгүй тус компанид шилүүлж, үр ашиггүй зардал гаргасан байна.	1	5,736.0					1	5,736.0		
Нийт	2	12,653.8	-	-			2	12,653.8	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								